



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/590

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Багц1-Булган аймаг, Булган сум, Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн спорт тоглоомын барилгын засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөнбулаг” ХХК-тай 339,877,645 (гурван зуун гучин есөн сая найман зуун далан долоон мянга зургаан зуун дөчин тав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөнбулаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

0334010801

Аймгийн Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 20-ны/ний өдрийн А.159.0 дугаар
захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	5 559 173	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	5 559 173	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2 674 431	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	19 800 000	Д.Батцогт
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
6	Баталгаат хугацаа	3 жил	П.Нөхөрлөлбаяр
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн